

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/06/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: П.Чанцалдулам Утас: 261740 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: С.Отгонхорлоо Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал...	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	15
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	15
3.5.2 Авлага	15
3.5.3 Урьдчилгаа	16
3.5.4 Бараа материал	16
3.5.5 Үндсэн хөрөнгө	17
3.5.6 Өр төлбөр	17
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	18
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	21
3.8 Аудитын гол асуудал	21
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	21
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
4. Аудитын илрүүлэлт	23
Албан шаардлага	23
Зөвлөмж	24
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	25
5.2 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ГХС	Гадаад харилцааны сайд
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЭСЯ	Элчин сайдын яам
ЕКГ	Ерөнхий консулын газар
БТГ	Байнгын төлөөлөгчийн газар
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ЗГНС	Засгийн газрын нөөц сан
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ДБҮЭГ	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
СЭЗХД	Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1321

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,691,881.7	15,879,271.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,569,798.4	6,531,390.0
33	АВЛАГА	13,964,068.0	4,736,627.9
34	УРЬДЧИЛГАА	330,554.4	221,245.4
35	БАРАА МАТЕРИАЛ	3,827,460.9	4,390,008.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	361,478,555.4	367,689,206.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	361,478,555.4	367,689,206.5
39100	Газар	33,342,495.7	33,342,495.7
39200	Биет хөрөнгө	300,325,940.1	302,706,120.9
39300	Биет бус хөрөнгө	27,810,119.5	31,640,589.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	387,170,437.1	383,568,478.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,048,610.7	1,371,674.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,046,848.0	1,371,674.1
41300	Өглөг	11,043,062.8	1,364,267.9
41400	Урьдчилж орсон орлого	3,785.2	7,406.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,762.7	-
42200	Урт хугацаат зээл	1,762.7	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	376,121,826.4	382,196,804.2
51	Засгийн газрын хувь оролцоо	376,121,826.4	382,196,804.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	201,762,839.7	205,625,011.6
51200	Хуримтлагдсан үр дүн	-73,769,789.0	-72,821,813.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	261,220,560.0	261,846,882.9
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-13,091,784.2	-12,453,276.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	387,170,437.1	383,568,478.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	140,691,583.5	105,721,608.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,091,964.3	12,938,248.8
120	Нийтлэг татварын бус орлого	37,770,199.9	12,938,248.8
122	Тусламжийн орлого	24,321,764.5	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78,599,619.2	92,783,359.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	160,060,874.3	117,340,597.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,979,578.4	117,166,293.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	123,169,507.2	92,566,415.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,414,832.3	33,714,607.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	993,540.7	1,229,936.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,055,182.7	15,524,541.5
2104	Хангамж, бараа материалын зардал	2,328,273.1	2,079,035.8
2105	Норматив зардал	9,350.9	46,714.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	716,446.9	804,559.6
2107	Томилолт, зочны зардал	5,727,248.2	3,049,999.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,880,586.6	13,908,393.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,044,045.8	22,208,625.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,810,071.3	24,599,878.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	81,295.8	174,303.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-19,369,290.7	-11,618,988.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	334,028.2	204,628.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	704,757.1	498,200.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-19,740,019.6	-11,912,560.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,627,113.4	-	393,627,113.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	168,997.1	-	168,997.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	393,796,110.6	-	393,796,110.6
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	2,103,814.6	-	2,103,814.6
7	Өмчид гарсан өөрчлөлт	-20,371.4	-	-20,371.4
8	Зарласан ногдол ашиг	-17,707.7	-	-17,707.7
9	Тайлант үеийн үр дүн	-19,740,019.6	-	-19,740,019.6
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	376,121,826.4	-	376,121,826.4
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,874,005.9	-	12,874,005.9
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	388,995,832.4	-	388,995,832.4
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	638,507.7	-	638,507.7
16	Өмчид гарсан өөрчлөлт	4,488,494.8	-	4,488,494.8
17	Зарласан ногдол ашиг	-13,470.0	-	-13,470.0
18	Тайлант үеийн үр дүн	-11,912,560.7	-	-11,912,560.7
19	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,196,804.2	-	382,196,804.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	133,988,947.2	106,174,413.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,527,717.4	12,720,280.1
120	Нийтлэг татварын бус орлого	35,171,998.1	12,483,090.9
122	Тусламжийн орлого	15,355,719.3	237,189.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,461,229.7	93,454,133.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	124,380,236.7	102,023,775.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	124,380,236.7	102,023,775.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,314,497.1	77,160,639.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,351,499.0	34,977,260.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,399,395.0	1,695,855.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,992,480.8	17,505,434.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,949,355.0	2,659,712.4
2105	Норматив зардал	14,457.7	38,357.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	678,774.4	892,972.3
2107	Томилолт, зочны зардал	5,535,382.1	3,004,487.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,274,755.1	9,973,416.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,118,398.1	6,413,142.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,065,739.6	24,863,135.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,608,710.5	4,150,638.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	142,140.6	206,825.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,326,203.0	5,350,963.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,326,203.0	5,350,963.0
2200	Дотоод эх үүсвэрээр	7,326,203.0	5,350,963.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,184,062.3	-5,144,137.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,089,432.6	-44,908.7
14	Бусад эх үүсвэр	146,960.0	198,311.4
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,236,392.6	243,220.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,335,215.5	-1,038,408.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,234,582.9	7,569,798.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,569,798.4	6,531,390.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,885,580,300.00	73,133,434,896.61	19,752,145,403.39	78.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,285,580,300.00	70,538,089,328.43	19,747,490,971.57	78.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,884,045,100.00	67,971,286,835.10	17,912,758,264.90	79.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,570,308,200.00	32,731,077,236.94	1,839,230,963.06	94.6
210101	Үндсэн цалин	33,247,122,200.00	31,536,380,033.50	1,710,742,166.50	94.8
210102	Нэмэгдэл	1,141,744,300.00	939,214,119.00	202,530,181.00	82.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	181,441,700.00	255,483,084.44	-74,041,384.44	140.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,456,790,900.00	1,209,306,605.67	247,484,294.33	83.0
210201	Тэтгэврийн даатгал	1,308,502,000.00	1,074,332,663.74	234,169,336.26	82.1
210202	Тэтгэмжийн даатгал	37,072,100.00	33,861,243.41	3,210,856.59	91.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,657,800.00	26,925,707.49	2,732,092.51	90.7
210204	Ажилгүйдлийн даатгал	7,414,400.00	6,701,991.50	712,408.50	90.3
210205	Эрүүл мэндийн даатгал	74,144,600.00	67,484,999.53	6,659,600.47	91.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,152,849,000.00	15,164,476,970.59	2,988,372,029.41	83.5
210301	Гэрэл, цахилгаан	1,342,900,000.00	998,155,510.28	344,744,489.72	74.3
210302	Түлш, халаалт	1,616,267,100.00	1,212,195,279.63	404,071,820.37	75.0
210303	Цэвэр, бохир ус	643,866,300.00	471,189,310.85	172,676,989.15	73.1
210304	Байрны түрээс	14,549,815,600.00	12,482,936,869.83	2,066,878,730.17	85.7
2104	Хангамж, бараа материалын зардал	3,302,759,800.00	2,086,254,634.02	1,216,505,165.98	63.1
210401	Бичиг хэрэг	372,682,600.00	251,168,705.52	121,513,894.48	67.3
210402	Тээвэр, шатахуун	1,130,580,100.00	712,674,212.80	417,905,887.20	63.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,162,560,800.00	877,154,644.78	285,406,155.22	75.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000,000.00	27,488,845.28	132,511,154.72	17.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	476,936,300.00	217,768,225.64	259,168,074.36	45.6
2105	Норматив зардал	101,035,900.00	19,668,595.80	81,367,304.20	19.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	101,035,900.00	19,668,595.80	81,367,304.20	19.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,164,559,000.00	1,540,275,143.47	1,624,283,856.53	48.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	945,719,000.00	782,424,271.98	163,294,728.02	82.7
210604	Урсгал засвар	2,218,840,000.00	757,850,871.49	1,460,989,128.51	34.1
2107	Томилолт, зочны зардал	6,427,751,300.00	2,979,023,652.25	3,448,727,647.75	46.3
210701	Гадаад албан томилолт	4,932,352,900.00	2,218,551,171.37	2,713,801,728.63	44.9
210702	Дотоод албан томилолт	5,982,900.00	4,473,230.00	1,509,670.00	74.7
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,489,415,500.00	755,999,250.88	733,416,249.12	50.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,310,493,100.00	9,286,222,010.17	4,024,271,089.83	69.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,212,247,200.00	1,446,067,418.06	1,766,179,781.94	45.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,100,000.00	2,100,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	8,713,667,400.00	7,611,184,086.89	1,102,483,313.11	87.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	194,500.00	-	100.0

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000,000.00	-	990,000,000.00	-
210807	Газрын төлбөр	84,077,200.00	28,074,695.21	56,002,504.79	33.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	308,162,800.00	198,557,310.01	109,605,489.99	64.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,397,497,900.00	2,954,981,986.19	2,442,515,913.81	54.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,103,183,000.00	508,054,070.16	1,595,128,929.84	24.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,294,314,900.00	2,446,927,916.03	847,386,983.97	74.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,401,535,200.00	2,566,802,493.33	1,834,732,706.67	58.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,471,325,800.00	2,234,046,757.33	1,237,279,042.67	64.3
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,471,325,800.00	2,234,046,757.33	1,237,279,042.67	64.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	930,209,400.00	332,755,736.00	597,453,664.00	35.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	224,000,000.00	216,383,892.00	7,616,108.00	96.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	673,709,400.00	95,031,844.00	578,677,556.00	14.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,500,000.00	21,340,000.00	11,160,000.00	65.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,600,000,000.00	2,595,345,568.18	4,654,431.82	99.8
221001	Их засвар	1,600,000,000.00	1,598,724,000.72	1,275,999.28	99.9
222001	Тонг төхөөрөмж	1,000,000,000.00	996,621,567.46	3,378,432.54	99.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,885,580,300.00	77,796,029,032.91	15,089,551,267.09	83.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	91,335,580,300.00	77,639,079,961.10	13,696,500,338.90	85.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	91,335,580,300.00	77,639,079,961.10	13,696,500,338.90	85.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,550,000,000.00	156,949,071.81	1,393,050,928.19	10.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	990,000,000.00	-	990,000,000.00	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	560,000,000.00	156,949,071.81	403,050,928.19	28.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,541,005,333.52	-4,541,005,333.52	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,875,218,956.78	-2,875,218,956.78	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	51	51		
610001	Төсвийн байгууллага	51	51		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	652	652		
620001	Удирдах ажилтан	60	60		
620002	Гүйцэтгэх ажилтан	370	370		
620003	Үйлчлэх ажилтан	222	222		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	652	652		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,222,711,437.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,079,637,497.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,661,411,787.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	524,970,985.00
210101	Үндсэн цалин	524,970,985.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,356,542.01
210201	Тэтгэврийн даатгал	5,556,542.01
210205	Эрүүл мэндийн даатгал	16,800,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,244,000.00
210301	Гэрэл, цахилгаан	15,060,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,504,000.00
210304	Байрны түрээс	367,680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,254,710.00
210401	Бичиг хэрэг	8,317,273.00
210402	Тээвэр, шатахуун	8,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,286,897.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,850,540.00
2105	Норматив зардал	18,688,700.00
210502	Хоол, хүнс	18,688,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	127,942,580.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	99,633,823.18
210602	Тавилга	26,238,757.79
210604	Урсгал засвар	2,070,000.00
2107	Томилолт, зочны зардал	25,464,030.00
210701	Гадаад албан томилолт	17,460,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,004,030.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	301,674,621.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296,551,629.07
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,069,992.80
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	53,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,231,815,617.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,172,482,027.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	59,333,590.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	418,225,709.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	161,927,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	136,927,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	256,298,609.60
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	4,471,570.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	251,827,039.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	143,073,940.24
2200	Дотоод эх үүсвэрээр	143,073,940.24
222001	Тоног төхөөрөмж	143,073,940.24
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,046,993,873.71

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,046,993,873.71
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	936,457,373.11
131103	ЗГНХ,ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,979,480,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,131,056,500.60
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-175,717,563.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	175,990,268.03
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	272,704.31

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын аудитор С.Отгонхорлоо гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор П.Чанцалдулам, аудитын менежер Д.Энхдалай, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/1472 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гадаад харилцааны яамны эрхэм зорилгыг “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчинг бүрдүүлэх, дэлхийн улс орнуудтай бодит харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхдээ “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай явуулах зорилтуудыг удирдлага болгоно” гэж үйл ажиллагааны зорилтоо тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл: Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дах монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хилийн чанадад хамгаалах зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг үндэслэн Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны батлагдсан төсвийн хуваарьт Сангийн сайдын 2020 оны 165 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тус яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2020 онд төлөвлөгөөт ажлын биелэлт болон, санхүүгийн хяналт шалгалт хийж үйл ажиллагаа сайжруулах зөвлөмжүүдийг өгч, биелэлтийг үнэлж ажилласан байна. Үүнд:

Харьяа байгууллагуудад өмнөх оны Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 төлбөрийн акт, 4 албан шаардлага, 26 зөвлөмжийн биелэлтийг гаргуулан Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтын 6.2.1-д заасны дагуу үнэлгээ хийхэд 23 ажил, арга хэмжээ 100.0 хувь, 5 ажил 70.0 хувь, 8 ажил, арга хэмжээ 30.0 хувьтай бөгөөд дундаж биелэлт нь 80.3 хувьтай бусад зөвлөмжүүдийг цаг тухайд нь хэрэгжүүлж ажилласан байна.

Гадаад харилцааны яамны 2018, 2019 оны худалдан авах үйл ажиллагаанд дотоод аудит хийж 9 зөвлөмж, мөн Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын 2019, 2020 оны үйл ажиллагаанд аудит хийж, нийт 34 зөвлөмж өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 117,838.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2,346.8 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,569.7 сая, эцсийн үлдэгдэл 6,531.3 сая төгрөг болж, 1,038.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	516.6	636.3	119.7
Төгрөг	9.6	0.2	(9.4)
Гадаад валют	500.4	635.7	135.3
Нэмэлт санхүүжилт	6.6	0.2	(6.4)
Банкинд байгаа бэлэн мөнгө	4,801.1	5,849.4	1,048.3
Төгрөг	1,300.1	2,718.4	1,418.3
Төрийн сангийн харилцах	4.2	4.2	(0.0)
Арилжааны банк дахь харилцах	1,126.6	2,714.2	1,587.6
Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	169.3	-	(169.3)
Гадаад валют	3,501.0	3,130.9	(370.1)
Арилжааны банк дахь харилцах	3,501.0	3,130.9	(370.1)
Замд яваа мөнгөн хөрөнгө	2,252.0	45.6	(2,206.4)
Дүн	7,569.7	6,531.3	(1,038.4)

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,038.4 сая төгрөгөөр буурсан нь дипломат төлөөлөгчийн газрын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, улсын төсөвт төвлөрүүлэх оны эцсийн замд яваа мөнгөн хөрөнгө буурснаас шалтгаалжээ. Энэ нь өмнөх онд замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,252.0 сая, тайлант онд 2,206.4 сая төгрөгөөр буурч 45.6 сая төгрөг болсон нь Эрээн дэх консулын газрын замд яваа мөнгөн хөрөнгө байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 13,963.9 сая, эцсийн үлдэгдэл 4,736.4 сая төгрөг болж, 9,227.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	115.7	-	(115.7)
Татаас, санхүүжилтийн авлага	240.9	217.6	(23.3)
Дансны авлага /ТӨҮГ/	643.6	514.8	(128.8)
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	8.8	23.6	14.8
Бусад авлага	12,954.9	3,980.4	(8,974.5)
Байгууллагаас авах авлага	12,499.8	3,525.1	(8,974.7)
Хувь хүмүүсээс авах авлага	455.1	455.4	0.3
Дүн	13,963.9	4,736.4	(9,227.5)

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд “Монголын мянганы сорилтын сан” УТҮГ-ын 8,962.3 сая төгрөгийн авлага Сангийн сайдын багцад шилжсэнтэй холбоотой байна. Мөн ДТГ-ын цалин, НДШ-ийн авлага 115.7 сая төгрөг, ДБҮГ ТӨҮГ-ын өмч ашиглалтын явцад

үүссэн Дипломат-95 байрны түрээсийн төлбөр тооцоо 12.5 сая, байр ашиглалтын төлбөр 116.2 сая, шатахууны 59.0 сая төгрөгийн авлагын дүнгээр тус тус буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд авлага 4,736.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 1,832.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, /ДТГ-ын 1,711.1 сая, ДБҮЭГ ТӨҮГ 53.8 сая, ГХЯ-ны байгууллагаас авах 96.7 сая, хувь хүнээс авах авлага 24.1 сая төгрөг /
- Олон жилийн насжилттай нийт 1,771.9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй /Дипломат төлөөлөгчийн газрын хилийн чандад суугаа Астана дахь элчин сайдын яамны 1,651.1 сая, ГХЯ-ны 120.8 сая төгрөг/ байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 446.4 сая, эцсийн үлдэгдэл 423.4 сая төгрөг болж, 23.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
УРЬДЧИЛГАА	330.5	221.2	(109.3)
Урьдчилж гарсан зардал	214.6	18.9	(195.7)
Урьдчилгаа тооцоо	115.9	202.2	86.3
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	115.9	197.3	81.4
Дүн	446.4	423.4	(23.0)

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл буурсан нь ГХЯ-ны “Галт хан” мэдээллийн аюулгүй байдлын лицензийн программын урьдчилж төлсөн зардал, гадаад томилолтын урьдчилгаа 63.3 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 3,827.4 сая, эцсийн үлдэгдэл 4,390.0 сая төгрөг болж, 562.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,034.4	1,178.9	144.5
Тусгай зориулалттай материал	1,034.4	1,178.9	144.5
Бэлэн бүтээгдэхүүн	15.3	14.6	(0.7)
Хангамжийн материал	2,777.7	3,196.5	418.8
Бичиг хэргийн материал	65.1	50.4	(14.7)
Аж ахуйн материал	109.8	178.9	69.1
Сэлбэг хэрэгсэл	834.9	844.3	9.4
Түлш, шатах тослох материал	36.0	25.2	(10.8)
Барилгын засварын материал	16.2	11.0	(5.2)
Хүнсний материал	202.9	217.1	14.2
Бусад хангамжийн материал	1,512.8	1,869.6	356.8
Дүн	3,827.4	4,390.0	562.6

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын данс 562.6 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн санхүүжилтээр худалдан авч Дипломат төлөөлөгчийн газарт шилжүүлсэн үнэт цаас 148.9 сая, тооллогоор илэрсэн болон үнэ төлбөргүй хүлээн авч орлогод бүртгэсэн 94.1 сая, Гадаад харилцааны

яамны тусгай зориулалтын материал буюу цахим болон энгийн гадаад паспорт 194.0 сая, бичиг хэргийн материал 61.4 сая, барилгын засварын материал 223.0 сая, бусад хангамжийн материал 225.0 сая, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-т шилжүүлсэн хангамжийн материал 3.1 сая, Юнескогийн монголын үндэсний комиссын бараа материалын үлдэгдэл 48.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 421,482.9 сая, эцсийн үлдэгдэл 423,855.5 сая төгрөг болж, 2,372.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	33,342.5	33,342.5	-
Биет хөрөнгө	360,161.0	358,666.4	(1,494.6)
Барилга, байгууламж, орон сууц	326,265.7	328,803.0	2,537.3
Авто-тээврийн хэрэгсэл	13,698.8	10,413.2	(3,285.6)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,287.1	6,751.7	(535.4)
Тавилга, аж ахуйн эд хогшил	6,758.7	6,476.9	(281.8)
Зам, гүүрний байгууламж	464.7	528.7	64.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	87.6	92.3	4.7
Бусад үндсэн хөрөнгө	378.4	380.0	1.6
Ном	22.5	23.2	0.7
Дуусаагүй барилга, байгууламж	5,197.5	5,197.4	(0.1)
Биет бус хөрөнгө	27,979.4	31,846.6	3,867.2
Программ хангамж	283.2	288.3	5.1
Бусад биет бус хөрөнгө	27,696.2	31,558.3	3,862.1
Дүн	421,482.9	423,855.5	2,372.6

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь Монгол Улсаас хилийн чанадад суугаа зарим Дипломат төлөөлөгчийн газруудын /Брюссель ЭСЯ, Бээжин ЭСЯ, Москва ЭСЯ-ны 1 дүгээр байранд их засвар/ байранд улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр шаардлагатай их засвар, сайжруулалт хийж бүртгэсэнтэй холбоотой байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын 4 дэх заалтын дагуу үнэлгээнд хамрагдаагүй Улаанбаатар хотод байршилтай Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-ын 2018 оноос хойш шинээр олж авсан 7-н газрын “Газар эзэмших, ашиглах эрх”-ийг Сангийн сайдын 2018 оны 207-р тушаалаар батлагдсан аргачлал, ТӨБЗГ-ын 2020 оны 85 дугаар тогтоолд үндэслэн 3,862.2 сая төгрөгөөр дахин үнэлж бусад биет бус хөрөнгийн дансанд нэмж бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний 2017 онд ашиглалтад орсон барилга дуусаагүй барилга байгууламжийн дансанд 5,197.4 сая төгрөгөөр бүртгэлтэй хэвээр байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 11,048.6 сая, эцсийн үлдэгдэл 1,379.0 сая төгрөг болж, 9,669.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,043.0	1,371.6	(9,671.4)
Ажилчидтай холбогдсон өглөг	15.1	1,364.3	1,349.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	11.4	0.0	(11.4)
Бусад өглөг	11,016.5	1,364.2	(9,652.3)
Байгууллагад төлөх өглөг	10,097.0	466.8	(9,630.2)
Хувь хүмүүст төлөх өглөг	38.8	57.4	18.6
Татварын өглөг /ТӨҮГ/	119.8	79.1	(40.7)
Дансны өглөг /ТӨҮГ/	760.8	760.8	-
Урьдчилж орсон орлого	3.8	7.4	3.6
Бусад урьдчилж орсон орлого	3.8	7.4	3.6
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1.8	0.0	(1.8)
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	1.8	0.0	(1.8)
Дүн	11,048.6	1,379.0	(9,669.6)

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэл буурсан нь “Монголын мянганы сорилтын сан” УТҮГ-ын байгууллагад төлөх 9,614.5 сая төгрөгийн төлбөр Сангийн сайдын багцад шилжсэн, ГХЯ-ны шатахууны төлбөр 59.0 сая, Дипломат төлөөлөгчийн газрын Брюссель дэх ЭСЯ-ны 116.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэх, барилгын дотоод засал хийлгэх их засварын төлбөр, Сан-Франциско дахь ЕКГ-ын 125.9 сая төгрөгийн өр, төлбөрийг тус тус барагдуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөрийн үлдэгдлээс 1,371.6 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /ДТГ 5.4 сая, ГХЯ-ны 24.6 сая төгрөг/ байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 376,122.0 сая, эцсийн үлдэгдэл 382,196.8 сая төгрөг болж, 6,074.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	201,762.8	205,625.0	3,862.2
Хуримтлагдсан үр дүн	-73,769.7	-72,821.8	947.9
Өмнөх үеийн үр дүн	-54,029.7	-60,909.2	(6,879.5)
Тайлант үеийн үр дүн	-19,740.0	-11,912.5	7,827.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	261,220.6	261,846.8	626.2
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-13,091.7	-12,453.2	638.5
Дүн	376,122.0	382,196.8	6,074.8

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс өссөн нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гарсантай холбоотой байна. Тухайлбал:

- Засгийн газрын оруулсан капитал данс Сангийн сайдын 2018 оны 207-р тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын 7-н газрыг дахин үнэлсэнтэй холбоотой 3,862.2 сая төгрөгөөр өссөн байна.
- Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны дүн ТӨБЗГ-ын “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 2020 оны 685 дугаар тогтоолоор Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын ашиглалтын хугацааг

сунгаж, шинэчлэн тогтоосон 713.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний дүнгээр нэмэгдсэн.

- Хуримтлагдсан үр дүн данс Дипломат төлөөлөгчийн газрын 638.5 сая төгрөгийн валютын ханшийн хөрвүүлгийн зөрүүгээр өссөн.
- Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансны дүн Дипломат төлөөлөгчийн газрын Москва дахь ЭСЯ-ны үндсэн хөрөнгийн ашиглалтын жил өөрчилсөнтэй холбоотой 13,001.3 сая төгрөгөөр, Мянганы сорилтын сан УТҮГ Сангийн сайдын төсвийн багцад шилжсэнтэй холбоотой 45.6 сая төгрөгөөр, Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс 81.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

ТЕЗ-ын төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг Дипломат төлөөлөгчийн газар 4,000.0 сая, ГХЯ-ны туслах үйл ажиллагааны орлогыг 1,550.0 сая төгрөгийг бүрдүүлж, төвлөрүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр Дипломат төлөөлөгчийн газар улсын тэмдэгтийн хураамжаас 1,635.4 сая, бусад орлого 4,419.5 сая, ГХЯ нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 107.5 сая төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Төсвийн төлөвлөлт

Тус ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 137,468.4 сая, хөрөнгө оруулалтын төсвийг 101,351.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс санхүүжилтийг 47,182.8 сая, хөрөнгө оруулалтыг 98,751.3 сая төгрөгөөр бууруулж, урсгал төсвийг 90,285.6 сая, хөрөнгө оруулалтын зардлыг 2,600.0 сая төгрөгөөр баталсан байна.

Цалингийн зардлыг 4,175.8 сая, хангамж бараа материалын зардлыг 1,779.3 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,133.6 сая, гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 2,267.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,119.8 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 35,706.7 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Нийт зардлын 91,335.6 сая төгрөгийг улсын төсвөөс, ГХЯ нь туслах үйл ажиллагааны орлого 560.0 сая, Олон улсын хамтын ажиллагааны сангаас үндсэн үйл ажиллагааны орлого 990.0 сая, нийт 92,885.6 сая төгрөг бүрдүүлж, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 91,335.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 1,878.5 сая төгрөгийг дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 73,133.4 сая төгрөг буюу 78.7 хувьтай байна. Батлагдсан төсөвт зардал бүлгийн дүнгээр хэтрээгүй боловч эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Үндсэн цалингийн зардал 1,839.2 сая, нэмэгдэл цалингийн зардал 1,710.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна. Тухайлбал: Арабын Бүгд Найрамдах Эмират Улсын Абу Дабид ЭСЯ болон худалдааны төлөөлөгчийн газар нээхээр урсгал зардал төсөвлөсөн боловч нээгдээгүйгээс нийт 341.2 сая төгрөгийн цалингийн зардал зарцуулагдаагүй.
- Улсын Их Хурлын 78, 79 дүгээр тогтоолуудаар нээгдэхээр шийдвэр гарсан боловч Минск дахь ЭСЯ, Манжуур дахь ЕКГ 2020 оны 10 дугаар сараас үйл ажиллагааг эхлүүлснээс шалтгаалан 878.4 сая төгрөгийн төсөв дутуу зарцуулагдсан;
- Зарим ДТГ-ын тэргүүн нарын томилгоо хийгдээгүй, хугацааны дундуур томилогдсон, зарим ажилтнууд эрүүл мэндийн болон бусад шалтгаанаас ажиллаагүй, орон тоо дутуу ажиллаж байгаа зэргээс шалтгаалан цалингийн зардлаас гадна нийгмийн даатгалын шимтгэл, байрны түрээс, эрүүл мэндийн даатгал, гадаад томилолт, хангамж, бараа материал, хичээл сургалтын зардлууд зарцуулагдаагүй үлдсэн;
- Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх санг Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор татан буулгаснаас бараа, үйлчилгээний бусад зардал 17,912.7 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан;
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд батлагдсан 990.0 сая төгрөгийн арга хэмжээ хэрэгжээгүйгээс гүйцэтгэл гараагүй;

Засгийн газрын гадаад шилжүүлгийн зардал 1,237.3 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь цар тахлаас шалтгаалан Олон улсын гишүүний татвар төлөгдөөгүйтэй холбоотой байна. Тухайлбал: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгчийн газрын орон нутгийн зардал 145.6 сая, Үйлдвэр хөгжлийн байгууллага 18.3 сая, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага 115.8 сая, Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн хөгжлийн хамтын ажиллагааны Колумбын төлөвлөгөөний байгууллага 48.5 сая, Ази, Европын сангийн 19.9 сая, Хөгжиж буй орнуудын Di-77 бүлгийн эдийн засгийн хамтын ажиллагааны сан 128.3 сая, Ардчилсан сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн 14.2 сая төгрөг буюу Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эдгээр Олон улсын байгууллагуудаас нэхэмжлэх ирүүлээгүйгээс гишүүнчлэлийн татварыг төлөөгүй байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 10,778.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нь хөрөнгө оруулалтын 17 төсөл, арга хэмжээнд батлагдсан 2,600.0 сая төгрөгийн төсвөөс гүйцэтгэлээр 2,595.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хоёр улсын Гадаад харилцааны яамд хоорондын айлчлалаар БНХАУ-аас Монгол Улсад өгсөн өмнөх оны хандивын үлдэгдэл 192.2 сая төгрөг болон Монгол Улсад суугаа ЭСЯ-аар дамжуулан Аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдээс хандивласан 129.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламж 936.4 сая, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 2,979.4 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,131.0 сая, нийт 5,046.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Гүйцэтгэлээр цалингийн зардалд 525.0 сая, НДШ-д 22.3 сая, байр ашиглалтын зардалд 385.2 сая, хангамж бараа материалын зардалд 23.2 сая, нормативт зардалд 18.7 сая, эд хогшил урсгал засварын зардалд 127.9 сая, томилолт зочны зардалд 25.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 301.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 3,231.8 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 256.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн, нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан маск, ариутгалын бодис, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, халдваргүйжүүлэлтийн зардалд төсвөөс 9.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

НЗДТГ-аас Дипломат төлөөлөгчийн газрын нэмэлт дансаар Тайпей дэх УБХТГ-ын санхүүжилтийг авч 1,030.4 сая төгрөгийг холбогдох газарт дамжуулсан боловч анхан шатны баримттай танилцах боломжгүй байлаа.

3.8 Аудитын гол асуудал

Дэлхий дахинаа тархсан халдварт цар тахалтай холбоотойгоор Засгийн газрын 2020 оны 40, 209 дүгээр тогтоолуудын дагуу Засгийн газрын нөөц сангаас Гадаад харилцааны яамны дансанд шилжүүлсэн хүмүүнлэгийн тусламжийн нийт 2,959.4 сая төгрөгөөс АНУ-д 2,408.6 сая, БНХАУ-д 550.8 сая төгрөгийн тусламжийг тус тус үзүүлсэн байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаатай холбоотой нийт 137 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 49 байгууллагын 2020 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд хийсэн дотоод аудитаар тухайн хуулийн хэрэгжилт 99.7 хувь, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан мэдээллийн тоогоор 92.6 хувийн гүйцэтгэлтэй гэсэн чанарын үзүүлэлттэй гарч өмнөх оноос 1.4 хувиар өссөн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 138.3 сая төгрөгийн 6 төлбөрийн актыг 100 хувь барагдуулсан, 159.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн 4 албан шаардлагын хэрэгжилт 96.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт 26 зөвлөмж өгснөөс 25 зөвлөмжийг хэрэгжүүлэн 1 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу зөвлөмжийн хэрэгжилт 92.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
		Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Төлбөрийн акт тогтоох	6	138.3	6	138.3	100.0
2	Албан шаардлага	4	159.0	4	159.0	95.0
3	Зөвлөмж	26	3,176.5	25	1,535.0	90.0
4	ДТГ-уудад албан шаардлага	5	-	4	-	85.0
Нийт дүн		36	3,473.8	35	1,832.3	92.5

Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана дахь ЭСЯ-ны удаан жил болсон авлагыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг даалгаж, ТНБД-д өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул ГХС-д албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар хилийн чанадад суугаа ДТГ-уудын санхүүгийн үйл ажиллагаанд анхаарч ажиллах талаар 5 албан шаардлага өгснөөс 85.0 хувийн биелэлттэй байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн 46 байгууллагын тайлан нэгтгэгддэг. Эдгээр газруудад 2019 оны сүүлийн хагас жил, 2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй, түүвэрт хамруулан аудитын тайланд нэгтгэсэн. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн 84.5 хувийг хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын зардал эзэлж байгаа тул аудитад хамруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 7 байгууллагын тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн, 1 байгууллагын санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан, 1 байгууллага Сангийн сайдын багцад шилжсэн байна.

Дипломат төлөөлөгчийн газруудын 2019 оны сүүлийн хагас жил, 2020 оны санхүүгийн тайлангууд аудитад хамрагдаагүй, тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд түүвэрт хамруулан нэгтгэгдсэн.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 7,097.6 сая төгрөгийн 23 алдааг илрүүлж аудитын явцад 2,742.2 сая төгрөгийн 3 алдааг залруулж, залруулагдаагүй нийт 7,563.3 сая төгрөгийн алдаа, зөрчлөөс 97.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 974.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлж, 3,640.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 12 зөвлөмж өгсөн.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 1,861.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,861.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Албан шаардлага

1. ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлтэй 4,736.6 сая төгрөгийн авлага, 1,371.6 сая төгрөгийн өр төлбөрөөс 1,832.0 сая төгрөгийн авлага, 29.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Дээрх авлагаас Астана дахь ЭСЯ-ны 1,651.1 сая төгрөгийн авлага нь өмнөх жилүүдэд үүссэн, найдваргүй болох эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулах, төлөх боломжтой өр төлбөрийг тайлант онд нь барагдуулж байх, олон жилийн насжилттай авлагад анхаарал хандуулан барагдуулах арга хэмжээг зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлээ.

2. Санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд 2017 оноос хойш бүртгэлтэй байгаа тус яамны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилгын асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, хөрөнгөнд бүртгэх ажлыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргахаас өмнө захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч хамтран барилга байгууламжид үзлэг хийж, зөрчлийг арилгуулж, Барилгын тухай

хуулийн 48.5.3, 48.5.4-т тус тус заасан дүгнэлтийг гаргасан байна”, 2.5-д “Захиалагч барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтэд Барилгын тухай хуулийн 48.5-д заасан баримт бичгийг хавсаргах бөгөөд уг баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зааврын дагуу хөтөлж бүрдүүлсэн байна” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

3. Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 137 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг арилгах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Татан буугдсан Олон улсын хамтын ажиллагааны санд үндсэн үйл ажиллагаанаас 990.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, зарцуулахаар төсвийг бодитой бус төлөвлөж батлуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэнтэй нийцэхгүй байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг үнэн зөв, бодитой төлөвлөж ажиллах, 2022 оны төсөвт төлөвлөж батлуулахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөгөөр/

Огноо:	Аудитын нэр:	<i>Гадаад харилцааны сайдын ЭАХБ-дын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн</i>	Аудитын код:	САГ-2021/6/СТ А-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд	сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	9	10
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ					
1	Тайлант онд татан буугдсан Олон улсын хамтын ажиллагааны санд үндсэн үйл ажиллагаанаас орлого бүрдүүлж, зарцуулахаар төсвийг бодитой бус төлөвлөж батлуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Гадаад харилцааны сайд, СЭЗХ-ийн дарга,	Б.Батцэцэг, Х.Алтантуяа
2	ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлтэй 4,736.6 сая төгрөгийн авлага, 1,371.6 сая төгрөгийн өр төлбөрөөс 1,832.0 сая төгрөгийн авлага, 29.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Дээрх авлагаас Астана дахь ЭСЯ-ны 1,651.1 сая төгрөгийн авлага нь өмнөх жилүүдэд үүссэн, найдваргүй болох эрсдэлтэй байна.	1,861.3	Албан шаардлага	Гадаад харилцааны сайд, СЭЗХ-ийн дарга,	Б.Батцэцэг, Х.Алтантуяа
3	Санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд 2017 оноос хойш бүртгэлтэй байгаа тус яамны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилгын асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, хөрөнгөнд бүртгэх ажлыг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт хангалтгүй байна.	-	Албан шаардлага	Гадаад харилцааны сайд, СЭЗХ-ийн дарга,	Б.Батцэцэг, Х.Алтантуяа

4	Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 137 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага	Гадаад харилцааны сайд, СЭЗХ-ийн дарга,	Б.Батцэцэг, Х.Алтантуяа
ТЕЗ-ЫН ДҮН		1,861.3			
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ					
1	Кызыл дэх ерөнхий консулын газрын 2020 оны төсвийн хэмнэлтийн үлдэгдэл 97,341,626.00 төгрөгийг Дипломат төлөөлөгчийн газраас олгох санхүүжилтээс суутган тооцоогүй байна.	97.3	Төлбөрийн акт тогтоох	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
2	Дипломат төлөөлөгчийн газар нь өмнөх аудитаар өгсөн “Мөнгөн кассын ажиллагааны журмыг хэрэгжүүлэн ажиллах” талаарх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, кассад 653.2 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байна.	653.2	Албан шаардлага өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
3	Тайлант онд Дипломат төлөөлөгчийн газрын багцын дүнгээр хэтрээгүй боловч Стокгольм дах ЭСЯ нь 2020 оны батлагдсан төсвөө 18.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	18.2	Албан шаардлага өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
4	Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд нийт 144 мэдээлэл байршуулахаас, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
5	ДТГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 3,830.9 сая төгрөгийн авлага, 413.8 сая төгрөгийн өглөг үүссэнээс тооцоо нийлж баталгаажуулаагүй авлага 1,831.9 сая, өглөг 5.4 сая төгрөг байна.	1,837.3	Зөвлөмж өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
ТТЗ-ЫН ДҮН		2,606.0			
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР					
1	Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн байгууллагын шилэн	157.5	Албан шаардлага өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо, Б.Болдбаатар

	дансны цахим хуудсанд нийт 144 мэдээлэл байршуулахаас, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлээгүй байна.				
2	Үндсэн хөрөнгийн шинэ чанартай хөрөнгийг бараа материалд бүртгэсэн байна.	31.9	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо, Б.Болдбаатар
3	Суудлын автомашин, түүхий эд анги, сэлбэг хэрэгсэл худалдан авахад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг нийт дүнгээс хасаж тооцсон.	3.8	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо, Б.Болдбаатар
4	Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, томилолтын болон бусад ажил гүйлгээнд сугалааны дугаартай буюу эцсийн хэрэглэгчийн төлбөрийн баримт /ибаримт/-ыг хавсаргасан байна.	30.7	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо, Б.Болдбаатар
5	Татварын өр төлбөрийг хуульд заасны дагуу төсөвт төвлөрүүлээгүй байна.	79	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо, Б.Болдбаатар
6	Тайлант хугацааны эцэст тооцоо нийлж үлдэгдэл баталгаажуулаагүй 8-н харилцагчийн авлага байна.	53.8	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо, Б.Болдбаатар
ТӨҮГ-ЫН ДҮН		356.7			
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ					
1	Тайлант онд 283.8 сая төгрөгийн авлага, 29.2 сая төгрөгийн өглөг үүссэнээс 120.8 сая төгрөгийн авлага, 24.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	145.4	Албан шаардлага өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
2	Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 144 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
3	Олон улсын хамтын ажиллагааны санд үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн зарцуулах эрхтэйгээр 990.0 сая төгрөгийн төсөв төлөвлөн батлуулсан боловч	990.0	Зөвлөмж өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа

	зарцуулалт гаргаагүй байна.				
4	ГХЯ-ны төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,550.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 1,442.4 сая төгрөгийг орлого тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалттай нийцэхгүй байна.	452.5	Зөвлөмж өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
5	Урсгал зардлаас нийт 161.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.	161.0	Зөвлөмж өгөх	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
ГХЯ-НЫ АППАРАТ		1,748.9			
ЮНЕСКОГИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИСС					
1	Тайлант хугацаанд байршуулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	-	Албан шаардлага өгөх	Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга, А.Алтантуяа
2	Унаа хоолны зардлыг хэрхэн олгох талаар байгууллагын дотоод журам болон холбогдох шийдвэрт тусгалгүйгээр албан хаагчдад унаа хоолны хөнгөлөлт хэлбэрээр олгосон байна.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга, А.Алтантуяа
3	Хувь хүмүүсээс авах 0.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.	0.5	Зөвлөмж өгөх	Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга, А.Алтантуяа
4	Гадаад томилолтоор ажилласан ажилтан, албан хаагчдаас томилолтын удирдамж, төлөвлөгөөг биелүүлсэн эсэхийг хянах зорилгоор томилолтын тайлан, мэдээ аваагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга, А.Алтантуяа
ЮНЕСКОГИЙН МУК-ЫН ДҮН		0.5			
ТШЗ-ЫН ДҮН		1,749.4			
ГХС-ЫН ЗАХБ-ЫН НИЙТ ДҮН		6,573.4			

5.2 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөгөөр/

Д/Д	№	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр					Нийт зөрчил		Залруулсан алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Дүгнэлтийн хэлбэр				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
					Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан										
A		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ																		
I. ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН																		
1	1	Гадаад харилцааны сайд			1				4	1,861.3	-	-	-	-	3	1,861.3	1	-
		ГХС-ын дүн			1				4	1,861.3	-	-	-	-	3	1,861.3	1	-
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ																		
II. ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР																		
2	1	Дипломат төлөөлөгчийн газар			1	-	-	-	5	2,606.0	-	-	1	97.3	3	671.4	1	1,837.3
		ДТГ-ын дүн			1	-	-	-	5	2,606.0	-	-	1	97.3	3	671.4	1	1,837.3
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ																		
3	1	Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар			1	-	-	-	7	2,390.5	1	2,033.9	-	-	1	157.5	5	199.1
4	2	Монголын мянганы сорилын сан							-	-	-	-	-	-	-	-	-	-
		ТӨҮГ-ын дүн			1	-	-	-	7	2,390.5	1	2,033.9	-	-	1	157.5	5	199.1
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																		
5	1	Гадаад харилцааны яам аппарат			1	-	-	-	7	2,100.6	2	351.7	-	-	2	145.4	3	1,603.5
6	2	Юнескогийн монголын үндэсний комисс			1	-	-	-	4	0.5	-	-	-	-	1	-	3	0.5
		ТШЗ-ын дүн			2	-	-	-	11	2,101.1	2	351.7	-	-	3	145.4	6	1,604.0
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН																		
7	1	Хилийн чандад байгаа монгол улсын иргэдэд туслах сан		1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		ТС-ын дүн		1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		ГХС-ын ЭАХБ-ын нийт дүн		1	5	0	0	0	27	8,958.9	3	2,385.6	1	97.3	10	2,835.6	13	3,640.4

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

/сая төгрөгөөр/

Д/Д	№	Харьяа байгууллага	Төлбөрийн акт тогтоосон зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
					Албан тушаал	Овог нэр
А	1		2	3	4	5
ТӨЛБӨРИЙН АКТ						
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ						
I. ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР						
1	1	Дипломат төлөөлөгчийн газар	Кызыл дэх ерөнхий консулын газрын 2020 оны төсвийн хэмнэлтийн үлдэгдэл 97.3 сая төгрөгийг Дипломат төлөөлөгчийн газраас олгох санхүүжилтээс суутган тооцоогүй байна.	97.3	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
ДТГ-ЫН ДҮН				97.3		
НИЙТ ТӨЛБӨРИЙН АКТЫН ДҮН				97.3		
АЛБАН ШААРДЛАГА						
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ						
I. ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД						
2	1	Гадаад харилцааны сайд	ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлтэй 4,736.6 сая төгрөгийн авлага, 1,371.6 сая төгрөгийн өр төлбөрөөс 1,832.0 сая төгрөгийн авлага, 29.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Дээрх авлагаас Астана дах ЭСЯ-ны 1,651.1 сая төгрөгийн авлага нь өмнөх жилүүдэд үүссэн, найдваргүй болох эрсдэлтэй байна.	1,861.3	Гадаад харилцааны сайд, СЭЗХ-ийн дарга	Б.Батцэцэг, Х.Алтантуяа
	1		Санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд 2017 оноос хойш бүртгэлтэй байгаа тус яамны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилгын асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, хөрөнгөнд бүртгэх ажлыг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт хангалтгүй байна.	-	Гадаад харилцааны сайд, СЭЗХ-ийн дарга	Б.Батцэцэг, Х.Алтантуяа
	1		Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 137 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Гадаад харилцааны сайд, СЭЗХ-ийн дарга	Б.Батцэцэг, Х.Алтантуяа
ТЕЗ-ЫН ДҮН				1,861.3		
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ						
II. ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР						
3	1	Дипломат төлөөлөгчийн газар	Дипломат төлөөлөгчийн газар нь өмнөх аудитаар өгсөн “Мөнгөн кассын ажиллагааны журмыг хэрэгжүүлэн ажиллах” талаарх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, кассад 653.2 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байна.	653.2	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа

	1		Тайлант онд Дипломат төлөөлөгчийн газрын багцын дүнгээр хэтрээгүй боловч Стокгольм дахь ЭСЯ нь 2020 оны батлагдсан төсвөө 18.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	18.2	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
	1		Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 144 мэдээлэл байршуулахаас, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
ДТГ-ЫН ДҮН				671.4		
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ						
III.ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ГАЗАР						
4	1	Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар	Тус байгууллага нь шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 144 мэдээлэл байршуулахаас, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 157.7 сая төгрөгийн орлого, зарлагын 12 ширхэг гүйлгээг мэдээлээгүй байна.	157.5	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ичинхорлоо, Б.Болдбаатар
ТӨҮГ-ЫН ДҮН				157.5		
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ						
IV.ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ						
5	1	Гадаад харилцааны яам-аппарат	Тайлант онд 283.8 сая төгрөгийн авлага, 29.2 сая төгрөгийн өглөг үүссэнээс 120.8 сая төгрөгийн авлага, 24.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна.	145.4	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
	1		Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 144 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	ГХЯ-ны ТНБД, СЭЗХ-ийн дарга	Н.Анхбаяр, Х.Алтантуяа
ГХЯ-ны аппаратын дүн				145.4		
V.ЮНЕСКОГИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИСС						
6	1	Юнескогийн монголын үндэсний комисс	Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 149 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга, А.Алтантуяа
Юнескогийн МҮК-ын дүн				-		
ТШЗ-ын дүн				145.4		
НИЙТ АЛБАН ШААРДЛАГЫН ДҮН				2,835.6		
ГХЯ-НЫ ЗАХЬ-ЫН ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН НИЙТ ДҮН				2,932.9		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 530/АО/110001

Улаанбаатар хот

С.АТ-2021/6/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гадаад харилцааны сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх нийт 4,736.6 сая төгрөгийн авлага, 1,371.6 сая төгрөгийн өр төлбөрөөс 1,832.0 сая төгрөгийн авлага, 29.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Дээрх авлагаас Астана дах ЭСЯ-ны 1,651.1 сая төгрөгийн авлага нь өмнөх жилүүдэд үүссэн, найдваргүй авлага болох эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулах, төлөх боломжтой өр төлбөрийг тайлант онд нь барагдуулж байх, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 581/А0110001

Улаанбаатар хот

САГ- 2021/Б/СТА ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гадаад харилцааны сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд 2017 оноос хойш бүртгэлтэй байгаа тус яамны "Ёслол хүндэтгэлийн өргөө"-ний барилгын асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, хөрөнгөнд бүртгэх ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.3-т "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргахаас өмнө захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч хамтран барилга байгууламжид үзлэг хийж, зөрчлийг арилгуулж, Барилгын тухай хуулийн 48.5.3, 48.5.4-т тус тус заасан дүгнэлтийг гаргасан байна", 2.5-д "Захиалагч барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтэд Барилгын тухай хуулийн 48.5-д заасан баримт бичгийг хавсаргах бөгөөд уг баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зааврын дагуу хөтөлж бүрдүүлсэн байна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, "Ёслол хүндэтгэлийн өргөө"-ний барилгын асуудлыг шийдвэрлэх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 582/А0110001

Улаанбаатар хот

С.АТ-20.21/6/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гадаад харилцааны сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 137 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ